

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: ДЦС-4/2020-06 дугаартай **Аргон, хагас автомат гагнуурын аппарат, плазм огтлогч нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС-4/2020-06**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Аргон, хагас автомат гагнуурын аппарат, плазм огтлогч нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2018 он, 2019 он/
- 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- 3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил:** Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онд ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

**Тендерийн хамт: 1,990,000 төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.**

**Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.**

Тендерийг 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.


Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4”**

**ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах**

**ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс**

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**



**У.ТӨМӨРХУЯГ**